

## МОНГОЛ УЛСЫН ЭРЧИМ ХҮЧНИЙ ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОГТООЛ

2026 оны ... дугаар  
сарын ...-ны өдөр

Дугаар ....

Улаанбаатар хот

### Дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай

Эрчим хүчний тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.21, 9 дүгээр зүйлийн 9.1.11, 9.2, Захиргааны ерөнхий хуулийн 67 дугаар зүйлийн 67.2 дах заалтыг тус тус үндэслэн Эрчим хүчний зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1. Эрчим хүчний зохицуулах хорооны 2018 оны 291 дүгээр тогтоолоор баталсан “Цахилгаанаар зохицуулалттай хангах тусгай зөвшөөрөл эзэмшигч, хэрэглэгч хоорондын аж ахуйн харилцааны дүрэм”-д хавсралтын ёсоор нэмэлт, өөрчлөлтийг оруулсугай.

2. Нэмэлт өөрчлөлт оруулсан дүрмийг захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлд бүртгэж “Захиргааны хэм хэмжээний актын эмхэтгэл”-д нийтлэгдсэн өдрөөс эхлэн мөрдөж ажиллахыг цахилгаан түгээх, цахилгаанаар зохицуулалттай хангах тусгай зөвшөөрөл эзэмшигч, хэрэглэгчдэд үүрэг болгосугай.

3. Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Ажлын алба (Б.Болор-Эрдэнэ)-нд даалгасугай.

ДАРГА

Э.ТҮВШИНЧУЛУУН

ЗОХИЦУУЛАГЧ

Л.ДАШМЯГМАРЖАВ

ЗОХИЦУУЛАГЧ

А.АЗБАЯР

ЗОХИЦУУЛАГЧ

Д.ЦОГОО

ЗОХИЦУУЛАГЧ

Б.ЭНХЖАРГАЛ

Цахилгаанаар зохицуулалттай хангах тусгай зөвшөөрөл эзэмшигч,  
хэрэглэгч хоорондын аж ахуйн харилцааны дүрэмд  
нэмэлт, өөрчлөлт оруулах тухай

1. “Цахилгаанаар зохицуулалттай хангах тусгай зөвшөөрөл эзэмшигч,  
хэрэглэгч хоорондын аж ахуйн харилцааны дүрэм”-д доор дурдсан агуулгатай  
дараах хэсэг, заалтыг нэмсүгэй. Үүнд :

**1/ 2 дугаар зүйлийн 2.3.14 дэх заалт:**

“2.3.14 холбогдох бусад нотлох баримт;”

**2/ 2 дугаар зүйлийн 2.4.7 дахь заалт:**

“2.4.7. холбогдох бусад нөхцөл;”

**3/ 2 дугаар зүйлийн 2.7 дахь хэсэг:**

“2.7 Гэрээг дүгнэхэд үүрэг хүлээсэн хэрэглэгч нь эрчим хүчийг хэмнэж, үр ашигтай  
хэрэглэснийг эрх бүхий байгууллага тогтоосон бол түүнийг захиалгаас дутуу  
хэрэглэсэн гэж үзэхгүй.”

**4/ 5 дугаар зүйлийн 5.1.9 дэх заалт:**

“5.1.9. Хэрэглэгчийн тоолуур хэмжих хэрэгслийн заалтын мэдээлэл татагдаагүй,  
хэрэглээг тоолоогүй тохиолдолд өмнөх 3 сарын дундаж хэрэглээгээр тухайн сарын  
бичилтийг хийж болно.”

**5/ 5 дугаар зүйлийн 5.3.2 дахь заалт:**

“Байнгын асаргаа шаардлагатай иргэн”

**6/ 5 дугаар зүйлийн 5.5 дахь хэсгийн бүрдүүлэх бичиг баримтад:**

- Өргөдөл
- Иргэний үнэмлэхийн хуулбар
- Асран хамгаалагчийн иргэний үнэмлэхийн хуулбар
- Өрх толгойлсон тухай нотлох баримт /нас барсны гэрчилгээ, Гэрлэсний  
бүртгэлгүй лавлагаа, Гэрлэлт дуусгавар болсны лавлагаа гэх мэт/
- Төрөл садангийн (садангүйн) лавлагаа
- Үл хөдлөх хөрөнгийн гэрчилгээний хуулбар;
- Газрын гэрчилгээний хуулбар
- Нийгмийн халамжийн тухай хуулийн 3.1.2-т заасан ядуурлын шугамаас  
доогуур өрхийн гишүүнийг тодорхойлсон тодорхойлолт

2. “Цахилгаанаар зохицуулалттай хангах тусгай зөвшөөрөл эзэмшигч,  
хэрэглэгч хоорондын аж ахуйн харилцааны дүрэм”-ийн дараах хэсэг, заалтыг доор  
дурдсанаар өөрчлөн найруулсугай. Үүнд :

## **1/ 2 дугаар зүйлийн 2.1 дэх хэсэг:**

“Эрчим хүчний тухай хууль, Сэргээгдэх эрчим хүчний тухай хууль, Эрчим хүч хэмнэлтийн тухай хууль, Иргэний хууль, Цахилгаан эрчим хүч хэрэглэх дүрэм, Нэгдсэн сүлжээний дүрэм, Эрчим хүчний шугам сүлжээг хамгаалах дүрэм, Цахилгаан дамжуулах, түгээх сүлжээний холболтын журам энэхүү дүрэм болон бусад холбогдох хууль тогтоомжийн хүрээнд хангагч, хэрэглэгчийн хооронд цахилгаан эрчим хүчээр хангах гэрээг өмчлөгчтэй, эсхүл өмчлөгчийн итгэмжлэгдсэн төлөөлөгчтэй байгуулна. Гэрээг цахим гарын үсэг ашиглан цахимаар хийж болно.”

## **2/ 2 дугаар зүйлийн 2.2.3 дахь заалт:**

“шугам сүлжээний эзэмшлийн заагийг техникийн нөхцөлд заасан холболтын цэгээр баталгаажуулсан байх”

## **3/ 2 дугаар зүйлийн 2.3.11 дэх заалт:**

“хангагч байгууллагын хаяг, утас;”

## **4/ 2 дугаар зүйлийн 2.3.15 дахь заалт:**

“хэрэглэгчийн өмчлөлийн дэд станц, шугам тоноглолын трансформаторын хоосон явалтын алдагдлын хувь хэмжээ зэргийг тусгаж, бусад шаардлагатай нотлох баримтуудыг хавсаргасан байна;”

## **5/ 2 дугаар зүйлийн 2.5 дахь хэсэг:**

“Хангагч нь хэрэглэгчдээс цахилгааны хэрэглээний захиалгыг авахдаа захиалгын хуудсаар жилд нэг удаа буюу 6 дугаар сарын 20-ноос 7 дугаар сарын 20-ны дотор авах бөгөөд Нэгдсэн сүлжээний дүрэмд заасан хугацаанаас хэтрүүлэхгүйгээр тодотгол хийж болно. Захиалгад хэрэглэгчийн суурилагдсан хүчин чадал, хүчин чадлын ашиглалт, хэрэглэх цахилгааны чадал, энергийн хэмжээ, хангагч, хэрэглэгчийн гарын үсэг, хаяг, хуулийн этгээдийн тамга, тэмдэг байна”

## **6 / 2 дугаар зүйлийн 2.10 дахь хэсэг:**

“Хэрэглэгч өөрийн өмчлөл (эзэмшил)-ийн өндөр хүчдэлийн шугам, тоноглолын засвар үйлчилгээ болон шуурхай ажиллагааны гэрээг эрчим хүчний чиглэлээр үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэй хуулийн этгээдтэй байгуулж болно.”

## **7/ 3 дугаар зүйлийн 3.6 дахь хэсэг:**

“Төлбөрийн үлдэгдэлтэй холбоотой цахилгаан хангамжийг түдгэлзүүлэх талаар хэрэглэгчдэд 48 цагийн өмнө урьдчилан мэдэгдэх.”

## **8/ 3 дугаар зүйлийн 3.7 дахь хэсэг:**

“Хэрэглэгчээс гаргасан өргөдөл, гомдол, санал, хүсэлтийг холбогдох хууль тогтоомжид заасан хугацаанд шийдвэрлэнэ”

## **9/ 3 дугаар зүйлийн 3.9 дэх хэсэг:**

“Сард нэгээс доошгүй удаа хэрэглэгчийн хэрэглэсэн цахилгааны бичилт хийж шаардлагатай тохиолдолд тоолуур, хэмжих хэрэгслийн хэвийн ажиллагааг шалгана”

**10/ 4 дүгээр зүйлийн 4.3.7 дахь заалт:**

“цахилгаанаар хангагчаас хэрэглэгчдэд үзүүлэх үйлчилгээний шаардлага MNS 5872:2019”

**11/ 5 дугаар зүйлийн 5.1.5 дахь заалт:**

“Тоолуур, гүйдэл, хүчдэлийн трансформаторын алдааг лабораториос тогтоох боломжгүй тохиолдолд сүүлийн нэг жилийн дундаж хэрэглээ, эсхүл өмнөх оны мөн үеийн хэрэглээ, эсхүл стандартын шаардлага хангасан хэмжүүрийг суурилуулснаас хойш 3 сарын хэрэглээний дунджаар тооцно”

**12/ 5 дугаар зүйлийн 5.1.6 дахь заалт:**

“Хэрэглэгч захиалга өгч, хэрэглээгээ цахилгаан эрчим хүчнээс бүрэн таслуулсны дараа шугам, трансформаторын алдагдал болон суурь төлбөрийг тооцохгүй.”

**13/ 5 дугаар зүйлийн 5.1.8 дахь заалт:**

“Хэрэглэгч нь өөрийн эзэмшлийн шугам сүлжээ, тоног төхөөрөмжид цахилгаан түгээх, цахилгаанаар зохицуулалттай хангах тусгай зөвшөөрөл эзэмшигч, цахилгаан дамжуулах шугам, дэд станцын засвар, угсралт, түүний туршилт тохируулга, дагалдах ажил, үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл эзэмшигчээр төлбөрт үйлчилгээг хийлгэж болно.”

**14/ 5 дугаар зүйлийн 5.3 дахь хэсэг:**

“Нийгмийн халамжийн дэмжлэг, туслалцаа зайлшгүй шаардлагатай хэрэглэгчдэд мөрдөх цахилгааны тариф”-т Нийгмийн халамжийн тухай хуулийн 3.1.2-т зааснаар амьжиргааны түвшин нь тухайн үеийн ядуурлын шугамаас доогуур үнэлэгдсэн дараах хэрэглэгчид хамрагдана. Үүнд:

**15/ 5 дугаар зүйлийн 5.3.1 дэх заалт:**

“Тэжээн тэтгэх төрөл садангүй, ганц бие ахмад настан”

**16/ 5 дугаар зүйлийн 5.3.3 дахь заалт:**

“0-18 хүртэлх насны гурав болон түүнээс дээш хүүхэдтэй өрх толгойлсон эх/ эцэг”

**17/ 5 дугаар зүйлийн 5.3.4 дэх заалт:**

“Хөгжлийн бэрхшээлтэй иргэн;”

**18/ 5 дугаар зүйлийн 5.5 дахь хэсэг:**

“Нийгмийн халамжийн дэмжлэг туслалцаа зайлшгүй шаардлагатай хэрэглэгчдэд мөрдөх цахилгааны тарифт хамрагдахыг хүссэн 5.3.1-5.3.4-т заасан хэрэглэгч нь хүсэлтээ бичгээр гаргах бөгөөд дараах материалуудыг бүрдүүлнэ. Үүнд:”

**19/ 5 дугаар зүйлийн 5.5 а) дахь заалт:**

“Тэжээн тэтгэх төрөл садангүй, ганц бие ахмад настан;”

## **20/ 5 дугаар зүйлийн 5.5 в) дэх заалт:**

“0-18 хүртэлх насны гурав болон түүнээс дээш хүүхэдтэй өрх толгойлсон эх/ эцэг”

Бүрдүүлэх материалд:

- “Баг, хорооны Засаг даргын тодорхойлолт”
- “Эрүүл мэндийн байгууллагын тодорхойлолт”, “Байнгын асаргаа шаардлагатай тухай эрүүл мэндийн байгууллагын тодорхойлолт”
- “Хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг тодорхойлсон үнэмлэхийн хуулбар эсвэл Эрүүл мэндийн байгууллагын тодорхойлолт”
- “Хүүхдүүдийн төрсний гэрчилгээний хуулбар”

## **21/ 5 дугаар зүйлийн 5.8 дахь хэсэг:**

“Нийгмийн халамжийн дэмжлэг, туслалцаа зайлшгүй шаардлагатай хэрэглэгч хэрэглэсэн цахилгаан эрчим хүчний төлбөрийг 3 сар дараалан төлөөгүй тохиолдолд гэрээг цуцлах үндэслэл болно.”

## **22/ 5 дугаар зүйлийн 5.9 дэх хэсэг:**

“Цахилгаан эрчим хүчийг зүй бусаар хэрэглэсэн нь баримтаар нотлогдсон эсхүл хугацаа заасан баримт бичгийн хугацаа дууссан нөхцөлд гэрээг цуцлах үндэслэл болно.”

3. “Цахилгаанаар зохицуулалттай хангах тусгай зөвшөөрөл эзэмшигч, хэрэглэгч хоорондын аж ахуйн харилцааны дүрэм”-ийн 5 дугаар зүйлийн 5.1.8 дахь заалтын “...Эрчим хүчний зохицуулах хорооны боловсруулсан аргачлалын дагуу...” гэснийг, мөн зүйлийн 5.1.4, 5.2.7, 5.2.9, 5.3.1, 5.3.1.2, 5.3.3-ийн г, 5.3.6, 5.3.7, 5.4.1 дэх заалтуудыг тус тус хассугай.

4. “Цахилгаанаар зохицуулалттай хангах тусгай зөвшөөрөл эзэмшигч, хэрэглэгч хоорондын аж ахуйн харилцааны дүрэм”-ийн “2.4.5” гэснийг “2.4.4” гэж, “2.4.6” гэснийг “2.4.5” гэж, “2.4.7” гэснийг “2.3.15” гэж, “2.4.8” гэснийг “2.4.6” гэж, “2.4.9” гэснийг “2.10” гэж, “2.7” гэснийг “2.8” гэж, “2.8” гэснийг “2.9” гэж, “5.1.5” гэснийг “5.1.4” гэж, “5.1.6” гэснийг “5.1.5” гэж, “5.1.7” гэснийг “5.1.6” гэж, “5.1.8” гэснийг “5.1.7” гэж, “5.1.9” гэснийг “5.1.8” гэж, “5.2.8” гэснийг “5.2.7” гэж, “5.2.10” гэснийг “5.2.8” гэж, “5.2.11” гэснийг “5.2.9” гэж, “5.2.12” гэснийг “5.2.10” гэж, “5.2.13” гэснийг “5.2.11” гэж, “5.2.14” гэснийг “5.2.12” гэж, “5.2.15” гэснийг “5.2.13” гэж, “5.2.16” гэснийг “5.2.14” гэж, “5.3.1.1” гэснийг “5.3.1” гэж, “5.3.1.2” гэснийг “5.3.2” гэж, “5.3.1.3” гэснийг “5.3.3” гэж, “5.3.1.4” гэснийг “5.3.4” гэж, “5.3.2” гэснийг “5.4” гэж, “5.3.3” гэснийг “5.5” гэж, “5.3.4” гэснийг “5.6” гэж, “5.3.5” гэснийг “5.7” гэж, “5.3.8” гэснийг “5.8” гэж, “5.3.9” гэснийг “5.9” гэж тус тус өөрчилсүгэй.

## ЦАХИЛГААНААР ЗОХИЦУУЛАЛТТАЙ ХАНГАХ ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ ЭЗЭМШИГЧ, ХЭРЭГЛЭГЧ ХООРОНДЫН АЖ АХУЙН ХАРИЛЦААНЫ ДҮРМИЙН ТӨСӨЛ

### Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Тусгай зөвшөөрөл эзэмшигч, хэрэглэгч хоорондын аж ахуйн харилцааны дүрмийн зорилго нь Эрчим хүчний тухай хуульд заасан цахилгаанаар зохицуулалттай хангах тусгай зөвшөөрөл эзэмшигчээс /цаашид “Хангагч” гэх/ хэрэглэгчийг цахилгаанаар хангахтай холбогдсон харилцааг зохицуулах, гэрээний нөхцөл, түүнд тавигдах шаардлага, үйлчилгээний түвшин, чанарын үзүүлэлт, төлбөр тооцооны нөхцөлийг тусгасан хэм хэмжээг тодорхойлоход оршино.

1.2. Энэхүү дүрмийг хангагч, хэрэглэгч болон шинээр гэрээ байгуулахыг хүссэн иргэн, хуулийн этгээд дагаж мөрдөнө.

### Хоёр. Гэрээний нөхцөл, шаардлага

2.1. Эрчим хүчний тухай хууль, Сэргээгдэх эрчим хүчний тухай хууль, Эрчим хүч хэмнэлтийн тухай хууль, Иргэний хууль, Цахилгаан эрчим хүч хэрэглэх дүрэм, Нэгдсэн сүлжээний дүрэм, Эрчим хүчний шугам сүлжээг хамгаалах дүрэм, Цахилгаан дамжуулах, түгээх сүлжээний холболтын журам энэхүү дүрэм болон бусад холбогдох хууль тогтоомжийн хүрээнд хангагч, хэрэглэгчийн хооронд цахилгаан эрчим хүчээр хангах гэрээг өмчлөгчтэй, эсхүл өмчлөгчийн итгэмжлэгдсэн төлөөлөгчтэй байгуулна. Гэрээг цахим гарын үсэг ашиглан цахимаар хийж болно.

2.2. Иргэн, хуулийн этгээд цахилгаан эрчим хүчээр хангах гэрээ байгуулахдаа дараах шаардлагыг хангасан байна.

- 2.2.1. хангагчаас олгосон техникийн нөхцөлийн шаардлагыг хангасан байх;
- 2.2.2. хэрэглэсэн цахилгааны тооцоог нийлж баталгаажуулан, өр төлбөрөө бүрэн барагдуулсан байх;
- 2.2.3. шугам сүлжээний эзэмшлийн заагийг техникийн нөхцөлд заасан холболтын цэгээр баталгаажуулсан байх;
- 2.2.4. тоолуур, хэмжих хэрэгслийг шалгаж, эрх бүхий байгууллагаар баталгаажуулсан байх;

2.3. Иргэн (айл өрх)-тэй байгуулах цахилгаан эрчим хүчээр хангах гэрээнд дараах нөхцөлийг тусгана.

- 2.3.1. хэрэглэх цахилгааны хэмжээ;
- 2.3.2. цахилгаан эрчим хүчний чанар;
- 2.3.3. үйл ажиллагааны чиглэл, үнэ тарифын ангилал;
- 2.3.4. талуудын эрх, үүрэг, хариуцлага;
- 2.3.5. хохирлыг тооцох журам болон гэрээнээс үүссэн маргааныг шийдвэрлэх;
- 2.3.6. гэрээг цуцлах, нэмэлт өөрчлөлт оруулах, дүгнэх журам;
- 2.3.7. гэрээний хугацааг тоогоор болон бичвэрээр давхар бичих;
- 2.3.8. шаардлагатай гэж үзвэл зарим хэрэглэгчдийн хувьд төлбөрийн батлан даалт гаргуулсан, барьцаа төлбөр төлсөн эсэх асуудлыг тусгах;

2.3.9. эзэмшлийн зааг /бүдүүвч, зургийн хамт/;  
2.3.10. хэрэглэгчийн шаардлагатай мэдээлэл;  
2.3.11. хангагч байгууллагын хаяг, утас;  
2.3.12. цахилгааны төлбөрийн үлдэгдэлтэй эсэх тухай хангагч байгууллагын тодорхойлолт;

2.3.13. иргэн (өмчлөгч, эзэмшигч)-ий үнэмлэх, газрын гэрчилгээ, кадастрын зураг, үл хөдлөх хөрөнгийн гэрчилгээний баталгаат хуулбар болон баг хорооны Засаг даргын тодорхойлолт, өмчлөгчийн итгэмжлэл, тоолуур, хэмжих хэрэгслийн баталгаажуулалтын гэрчилгээ;

2.3.14. холбогдох бусад нотлох баримт;

2.3.15. хэрэглэгчийн өмчлөлийн дэд станц, шугам тоноглолын трансформаторын хоосон явалтын алдагдлын хувь хэмжээ зэргийг тусгаж, бусад шаардлагатай нотлох баримтуудыг хавсаргасан байна;

2.4. Хуулийн этгээдтэй байгуулах цахилгаан эрчим хүчээр хангах гэрээнд энэ зүйлийн 2.3-т зааснаас гадна дараах нөхцөлийг тусгана.

2.4.1. хэрэглэгчийн зэрэглэл, зэрэглэлийг хангах техникийн боломж;

2.4.2. цахилгаан хэрэглээний жил, улирал, сарын хуваарь;

2.4.3. шугам сүлжээний эзэмшлийн зааг, зарчмын схем, техникийн өгөгдлүүд, ажиллагааны горим, хамгаалалтын болон автоматикийн хэрэгслүүдийн тавилууд;

2.4.4. төлбөр тооцооны хэрэгслийн байршил;

2.4.5. төлбөр тооцоонд ашиглаж байгаа гүйдэл, хүчдэлийн трансформатор, тоолуур, хэмжих хэрэгслийн хэв маяг /тип, марк/, үржих коэффициент, үйлдвэрлэгчийн дугаар;

2.4.6. шаардлагатай тохиолдолд хэрэглэгч аж ахуйн нэгж, байгууллагын төлбөрийн чадварын талаар харилцагч банкны байгууллагаас гаргасан баталгаа болон тэдгээрийн харилцах данснаас төлбөрийг банкны байгууллагаар шууд хийлгэх нөхцөл, төлбөрийн барьцаа;

2.4.7. холбогдох бусад нөхцөл;

2.5. Хангагч нь хэрэглэгчдээс цахилгааны хэрэглээний захиалгыг авахдаа захиалгын хуудсаар жилд нэг удаа буюу 6 дугаар сарын 20-ноос 7 дугаар сарын 20-ны дотор авах бөгөөд Нэгдсэн сүлжээний дүрэмд заасан хугацаанаас хэтрүүлэхгүйгээр тодотгол хийж болно. Захиалгад хэрэглэгчийн суурилагдсан хүчин чадал, хүчин чадлын ашиглалт, хэрэглэх цахилгааны чадал, энергийн хэмжээ, хангагч, хэрэглэгчийн гарын үсэг, хаяг, хуулийн этгээдийн тамга, тэмдэг байна.

2.6. Хэрэглэгч захиалгаа буруу өгсөн, эсвэл цаг хугацаанд нь захиалгадаа өөрчлөлт оруулаагүй бол хариуцлагыг хангагч хүлээхгүй. Гэрээг дүгнэхэд захиалгаас илүү, дутуу хэрэглэсэн шалтгааныг талууд харилцан дүгнэж, хэн буруутай нь гэрээнд заасан хариуцлага хүлээнэ.

2.7 Гэрээг дүгнэхэд үүрэг хүлээсэн хэрэглэгч нь эрчим хүчийг хэмнэж, үр ашигтай хэрэглэснийг эрх бүхий байгууллага тогтоосон бол түүнийг захиалгаас дутуу хэрэглэсэн гэж үзэхгүй.

2.8. Хэрэглэгч нь техникийн хувьд боломжтой бол хангагч байгууллагаа сонгон үйлчлүүлэх эрхтэйгээр аж ахуйн харилцаанд оролцоно.

2.9. Хангагч нь аж ахуйн нэгж, байгууллага, хуулийн этгээдтэй жил бүр төлбөрийн тооцоог нийлж, гэрээг дүгнэж, төлбөр тооцоо, өр авлагыг баталгаажуулна. Ахуйн буюу айл өрхийн хэрэглэгчтэй гэрээний хугацаа дуусахад гэрээг дүгнэж, тэмдэглэл үйлдэнэ. Шаардлагатай үед жил бүр дүгнэж болно.

2.10. Хэрэглэгч өөрийн өмчлөл (эзэмшил)-ийн өндөр хүчдэлийн шугам, тоноглолын засвар үйлчилгээ болон шуурхай ажиллагааны гэрээг эрчим хүчний чиглэлээр үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэй хуулийн этгээдтэй байгуулж болно.

### **Гурав. Үйлчилгээний түвшин**

Хангагч нь дараах үйлчилгээний түвшнийг хэрэглэгчид үзүүлнэ.

3.1. Хэрэглэгчийг худалдан авах гэрээнд заасан тоо хэмжээ, чанарын шаардлага хангасан цахилгаанаар хангана.

3.2. Аваар саатлаас урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулна.

3.3. Хэрэглэгчийг цахилгаанаар найдвартай хангахад шаардагдах ажиллах хүч, материал, тоног төхөөрөмж, машин механизмыг бэлэн байдалд байлгана.

3.4. Хэрэглэгчид соёлтой үйлчилж, тэдний эрх ашигт нийцсэн төрөл бүрийн мэргэжлийн сургалт, сурталчилгааны ажлыг зохион байгуулна.

3.5. Хэрэглэгчийн цахилгаан хангамжийн найдвартай байдал, тасалдлын хугацаа нь цахилгаан сүлжээнд холбогдсон техникийн байдлаас хамаарч дараах хэмжээнд байна. Үүнд:

3.5.1. Нэгдүгээр зэрэглэлийн хэрэглэгч нь хангагчийн түгээх сүлжээгээр дамжин бие биеэс үл хамаарах хоёр талын тэжээл бүхий үндсэн ба бэлтгэл шугамтай, үндсэн тэжээлийн шугам хүчдэлгүй болоход хэрэглэгчийн цахилгаан тоног төхөөрөмж уг шугамаас салж бэлтгэл шугамд залгагдах автомат удирдлагатай байвал цахилгаан хангамжийн тасалдлын зөвшөөрөгдөх хугацаа нь нэг талын тэжээл тасрахад бэлтгэл тэжээл нь автоматаар залгагдах хугацаагаар тодорхойлогдоно.

3.5.2. Нэгдүгээр зэрэглэлийн хэрэглэгчид нь хангагчийн харьяаны шугам сүлжээгээр тэжээгддэг 2 талын тэжээлтэй байхаас гадна өөрийн мэдлийн аваарын эх үүсвэртэй байх бөгөөд эдгээрийн аль нэг нь тасрахад өөр хоорондоо автоматаар залгагдах схемтэй байна. Хэрэглэгчийн харьяаны эрчим хүчний эх үүсвэрийн суурилагдсан чадал нь түүний тасралтгүй ажиллагаатай байх нэгжүүд /байрууд/-ийг хангахад хүрэлцэхүйц хэмжээтэй байна. Эх үүсвэр, тэжээлүүдийн ажиллах дарааллыг эрчим хүчээр хангах гэрээнд тусгана.

3.5.3. Хоёрдугаар зэрэглэлийн хэрэглэгч нь хангагчийн түгээх сүлжээнд бие биеэс үл хамаарах хоёр талын тэжээл бүхий үндсэн ба бэлтгэл шугамаар холбогдсон боловч үндсэн тэжээлийн шугам хүчдэлгүй болоход хэрэглэгчийн цахилгаан тоног төхөөрөмж уг шугамаас салж бэлтгэл шугамд залгагдах автомат удирдлага байхгүй, энэ үйлдлийг хангагч очиж гүйцэтгэдэг бол цахилгаан хангамжийн тасалдлын зөвшөөрөгдөх хугацаа нь жижүүрийн буюу шуурхай үйлчилгээний явуулын бригадын хүмүүс бэлтгэл тэжээлийг залгахад шаардагдах хугацаагаар тодорхойлогдоно.

3.5.4. Гуравдугаар зэрэглэлийн хэрэглэгч нь хангагчийн түгээх сүлжээнээс ганц шугам трансформатораар холбогдсон тэдгээр нь гэмтсэн тохиолдолд хангагч очиж сэргээн засварладаг бол цахилгаан хангамжийн тасалдлын хугацаа 24 цагаас ихгүй байна.

3.6. Төлбөрийн үлдэгдэлтэй холбоотой цахилгаан хангамжийг түдгэлзүүлэх талаар хэрэглэгчдэд 48 цагийн өмнө урьдчилан мэдэгдэх.

3.6.1. Хэрэглэгчийн захиалгаар ажил гүйцэтгэхэд бусад хэрэглэгчдийн цахилгаан хангамжийг түр хугацаагаар түдгэлзүүлэх шаардлагатай бол түдгэлзүүлэхээс 24-өөс доошгүй цагийн өмнө хэрэглэгчид мэдэгдэнэ.

3.7. Хэрэглэгчээс гаргасан өргөдөл, гомдол, санал, хүсэлтийг холбогдох хууль тогтоомж, стандартад заасан хугацаанд шийдвэрлэнэ.

3.8. Байгалийн гамшиг, давагдашгүй хүчин зүйлийн шинжтэй нөхцөл байдал үүссэнээс бусад үед хэсэг бүлэг хэрэглэгчдийн цахилгаан хангамж тасарсан тохиолдолд, энэ тухай хэрэглэгч мэдэгдсэнээс хойш 24 цагийн дотор хэрэглэгчдийн цахилгаан хангамжийг сэргээнэ.

3.9. Сард нэгээс доошгүй удаа хэрэглэгчийн хэрэглэсэн цахилгааны бичилт хийж шаардлагатай тохиолдолд тоолуур, хэмжих хэрэгслийн хэвийн ажиллагааг шалгана.

3.10. Тооцооны тоолуурыг сүлжээнээс салгах, холбох үед хэрэглэгчийн төлөөллийг байлцуулан тоолуурын заалтыг тусгай хуудсанд тэмдэглэнэ. Тухайн тэмдэглэлийн хуудсанд дээрх үйлдлийг гүйцэтгэсэн ажилтны нэр, албан тушаал, утасны дугаар, үйлдсэн он, сар, өдөр, цагийг тодорхой бичиж 2 хувь үйлдэн, хангагч, хэрэглэгчийн гарын үсгээр баталгаажуулан тус бүрд нэг нэг хувийг авна.

### **Дөрөв. Цахилгаан эрчим хүчний чанарын үзүүлэлт**

4.1. Хангагч нь стандартын шаардлагад нийцсэн эрчим хүчээр хэрэглэгчийг хангана.

4.2. Хэвийн болон аваарын горимын үед цахилгаан эрчим хүчний хүчдэл, давтамжийн хэлбэлзлийн хязгаар нь Монгол улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа стандарт, техник ашиглалтын дүрэм болон нэгдсэн сүлжээний дүрэмд заасан хэм хэмжээнд байгаа тохиолдолд стандартын шаардлага хангасан эрчим хүч гэж үзнэ.

4.3. Хангагч нь дараах стандартуудыг мөрдлөг болгон ажиллана.

4.3.1. цахилгаан сүлжээ, хэвийн хүчдэл MNS 1500:82;

4.3.2. стандарт хүчдэл MNS IEC 38:2001;

4.3.3. стандартчилсан давтамж MNS IEC 196:2001;

4.3.4. цахилгаан эрчим хүчний чанар, нэр томъёо, тодорхойлолт MNS 2980:2003;

4.3.5. 25-2500 кВА чадалтай, 10 кВ хүртэл хүчдэлтэй иж бүрэн трансформаторын дэд өртөө, техникийн ерөнхий шаардлага MNS 5643:2006;

4.3.6. цахилгаан эрчим хүч. техник хэрэгслийн цахилгаан соронзон зохицол. ерөнхий зориулалтын цахилгаан хангамжийн систем дэх цахилгаан эрчим хүчний чанарын норм MNS 1778:2007;

4.3.7. цахилгаанаар хангагчаас хэрэглэгчдэд үзүүлэх үйлчилгээний шаардлага MNS 5872:2019;

4.3.8. Хэрэглэгч нь өөрийн байр орон сууцанд байгаа цахилгааны хуваарилах самбар суурилуулсан өрөөг зориулалтын дагуу тоноглож, шатах, тэсрэх материал болон бусад эд хогшлыг байрлуулахгүй байх.

4.3.9. Хэрэглэгч нь өөрийн цахилгаан тоног төхөөрөмжийн газардуулгын эсэргүүцлийг стандарт хэмжээнд байлгах, мөн барилга байшин шинээр барьсан, хүчний тоног төхөөрөмж нэмж суурилуулсан, барилга байгууламжид их засвар орсны дараа эрх бүхий мэргэжлийн байгууллагаар хэмжилт хийлгэж, баталгаажуулсан байна.

## **Тав. Цахилгаан эрчим хүчний төлбөр, тооцоо**

### **5.1. Төлбөр тооцооны ерөнхий нөхцөл:**

5.1.1. Хангагч, хэрэглэгч нь Эрчим хүчний зохицуулах хорооноос тогтоосон хэрэглэгчийн үнэ, тарифаар төлбөр, тооцоог хийнэ.

5.1.2. Хэрэглэсэн цахилгаан эрчим хүчний төлбөрийн нэхэмжлэл банканд очсоноос хойш алданги тооцож эхлэх болон цахилгаан эрчим хүчээр түдгэлзүүлж эхлэх хоногуудыг тус тус хэрэглэгчтэй байгуулж буй гэрээгээр зохицуулна.

5.1.3. Цахилгаан эрчим хүчээр түдгэлзүүлсэн ч төлбөр төлөгдөх хүртэлх хугацаанд гэрээнд заасан хувь хэмжээгээр алданги тооцно.

5.1.4. Цахилгаан тоолуур, гүйдэл, хүчдэлийн трансформаторын хэвийн ажиллагаа алдагдсан нь хэрэглэгчээс шалтгаалаагүй болохыг Хэмжилзүйн хяналтын улсын байцаагчийн дүгнэлтээр тогтоогдсон тохиолдолд эрх бүхий лабораторийн хэмжилтээр гарсан алдааны хувь хэмжээг үндэслэн хохирлыг холбогдох тал нь хариуцна.

5.1.5. Тоолуур, гүйдэл, хүчдэлийн трансформаторын алдааг лабораториос тогтоох боломжгүй тохиолдолд сүүлийн нэг жилийн дундаж хэрэглээ, эсхүл өмнөх оны мөн үеийн хэрэглээ, эсхүл стандартын шаардлага хангасан хэмжүүрийг суурилуулснаас хойш 3 сарын хэрэглээний дунджаар тооцно.

5.1.6. Хэрэглэгч захиалга өгч, хэрэглээгээ цахилгаан эрчим хүчнээс бүрэн таслуулсны дараа шугам, трансформаторын алдагдал болон суурь төлбөрийг тооцохгүй.

5.1.7. Тухайн хэрэглэгчийн онцлогт тохируулан конденсатор, синхрон хөдөлгүүрийг түгээгчээс олгосон техникийн нөхцөлийн дагуу суурилуулсан бол ажлын горимыг хангагч, хэрэглэгч талууд харилцан зөвшилцөж тогтоох ба Эрчим хүчний зохицуулах хорооноос баталсан журмын дагуу хэрэглэгчийн чадлын итгэлцүүр (cosφ)-ээс хамааруулж төлбөрийг тооцно.

5.1.8. Хэрэглэгч нь өөрийн эзэмшлийн шугам сүлжээ, тоног төхөөрөмжид цахилгаан түгээх, цахилгаанаар зохицуулалттай хангах тусгай зөвшөөрөл эзэмшигч, цахилгаан дамжуулах шугам, дэд станцын засвар, угсралт, түүний туршилт тохируулга, дагалдах ажил, үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл эзэмшигчээр төлбөрт үйлчилгээг хийлгэж болно.

5.1.9. Хэрэглэгчийн тоолуур хэмжих хэрэгслийн заалтын мэдээлэл татагдаагүй, хэрэглээг тоолоогүй тохиолдолд өмнөх 3 сарын дундаж хэрэглээгээр тухайн сарын бичилтийг хийж болно.

### **5.2. Чадлын төлбөр тооцох нөхцөл:**

5.2.1. Аж ахуйн нэгж, байгууллагын цахилгаан эрчим хүчний хэрэглээнд энергийн болон чадлын төлбөр, харин айл өрхийн цахилгаан хэрэглээнд энергийн болон суурь төлбөр тооцно.

5.2.2. Цахилгааны тоолуурыг мэдээлэл хадгалах, шилжүүлэх техникийн боломжоос нь хамааруулан дараах байдлаар ангилна.

5.2.2.1. Эрчим хүчний тухай хуулийн 16.3.3-т заасан шаардлагыг хангасан, оройн 17.00-22.00 цагийн хооронд хэрэглэгчийн хэрэглэсэн чадлын эгшин зуурын утгыг бүртгэж, санах боломжтой тоолуурыг чадлыг бүртгэх боломжтой тоолуур;

5.2.2.2. Эрчим хүчний тухай хуулийн 16.3.3-т заасан шаардлагыг хангасан хэрэглэгчийн хэрэглэсэн чадлын эгшин зуурын утгыг бүртгэх боломжгүй тоолуурыг чадлыг бүртгэх боломжгүй тоолуур;

5.2.2.3. Эрчим хүчний тухай хуулийн 16.3.3-т заасан шаардлагыг хангасан чадлын утгыг мөн өдөр, орой, шөнийн хэрэглээг бүртгэх боломжгүй тоолуурыг энгийн тоолуур;

5.2.2.4. Эрчим хүчний тухай хуулийн 16.3.3-т заасан шаардлагыг хангасан өдрийн, оройн, шөнийн хэрэглээг бүртгэх боломжтой тоолуурыг цагийн ялгаварт тоолуур;

5.2.3. Чадлын төлбөр тооцох чадлын утгыг тухайн хэрэглэгчийн цахилгааны тоолуурын мэдээлэл хадгалах, шилжүүлэх техникийн боломжоос хамааруулан дараах байдлаар тооцно.

5.2.3.1. Тодорхой хугацааны интервалд чадлын утгыг бүртгэх боломжтой тоолууртай хэрэглэгчийн төлбөр тооцох чадлын хэмжээг тоолуурын санах байгууламжид бүртгэгдсэн чадлын мэдээлэлд үндэслэн тухайн сарын өдрүүдийн оргил ачаалалд (17.00-22.00 цаг) оролцсон хамгийн их чадлын дундаж утгаар тооцно. Үүнд:

а/ Оргил ачааллын үргэлжлэх хугацаа гэж эрчим хүчний системийн хамгийн их ачаалал үргэлжлэх хугацаа буюу хоногийн 17.00-22.00 цаг байна.

б/ Хэрэглэгчийн оргил ачаалалд оролцсон хамгийн их чадал гэж оргил ачааллын хугацаанд хэрэглэсэн хамгийн их чадлын утга байна.

в/ Хамгийн их чадлын дундаж утга гэж тухайн сарын хуанлийн өдрүүдийн оргил ачаалалд оролцсон хамгийн их чадлын утгуудын дундаж утгыг хэлнэ.

5.2.4. Зарим төрлийн тоолуур нь 30 минутын давтамжтайгаар зөвхөн дундаж чадал ( $P_{\text{дундаж}}$ ) бүртгэх боломжтой байх нөхцөлд эдгээр өгөгдлөөс тухайн өдрийн оргил ачаалал үргэлжлэх хугацаа (17.00-22.00 цаг)-нд бүртгэгдсэн хамгийн их дундаж чадлын утгыг төлбөр тооцох үзүүлэлт болгож бүртгэнэ. Хэрэглэгчийн тухайн сард хэрэглэсэн хамгийн их чадал буюу чадлын төлбөр тооцох чадлыг өдөр бүрд бүртгэгдсэн хамгийн их чадлын нийлбэрийг нийт өдрийн тоонд хувааж дундчилж тооцно.

$$P_{\text{х.и.сар}} = \frac{\sum P_{\text{х.и. сарын өдөр}}}{t_{\text{сарын өдөр}}}, \text{ кВт}$$

$P_{\text{х.и. сар}}$  – Хэрэглэгчийн тухайн сарын оргил ачааллын үед (17.00-22.00 цаг) хэрэглэсэн хамгийн их чадлын дундаж утга (кВт);

$P_{\text{х.и. сарын өдөр}}$  – Хэрэглэгчийн тухайн сарын хуанлийн өдрийн 17.00-22.00 цагийн хооронд хэрэглэсэн хамгийн их чадал;

$t_{\text{сарын өдөр}}$  – Тухайн сарын хуанлийн өдрийн тоо буюу бичилт хоорондын хугацаа;

Хэрэглэгчийн хамгийн их чадал ( $P_{\text{max}}$ )-ын мэдээлэл тоолуурын санах ойд 30 минутын давтамжтайгаар бүртгэгдсэн байх ба эдгээр өгөгдлөөс тухайн өдрийн оргил ачаалал үргэлжлэх хугацаа (17.00-22.00цаг)-нд бүртгэгдсэн хамгийн их чадлын утгыг төлбөр тооцох үзүүлэлт болгож бүртгэнэ.

5.2.5. Чадлын утгыг бүртгэх боломжгүй, энгийн тоолууртай хэрэглэгчийн төлбөр тооцох чадлын хэмжээг тогтоохдоо тухайн сарын нийт цахилгаан энергийн хэмжээг *хэрэглэгчийн ажиллах хугацаа* (хоногийн 12 цаг)-г тухайн сарын өдрийн тоо (бичилт хоорондын хугацаа)-гоор үржүүлсэн дүнд харьцуулж тодорхойлно. Үүнд:

$$P_{\text{х.и. сар}}^{\text{энгийн}} = \frac{\sum W_{\text{сар}}}{12 \text{ цаг} * t_{\text{сарын өдөр}}}, \text{ кВт}$$

$P_{\text{х.и. сар}}^{\text{энгийн}}$  – Энгийн тоолууртай хэрэглэгчийн тухайн сард хэрэглэсэн хамгийн их чадлын дундаж утга (кВт);

$W_{\text{сар}}$  – Сарын цахилгааны хэрэглээ (кВт.ц);

$t_{\text{сарын өдөр}}$  – Тухайн сарын хуанлийн өдрийн тоо буюу бичилт хоорондын хугацаа;

5.2.6. Чадлын утгыг бүртгэх боломжгүй, цагийн ялгаварт тоолууртай хэрэглэгчийн төлбөр тооцох чадлын хэмжээг тогтоохдоо тухайн сарын оргил ачааллын цагт ногдох нийт цахилгаан энергийн хэмжээг хэрэглэгчийн оргил ачааллын үргэлжлэх хугацаа (17.00-22.00 цагийн хооронд 5 цаг)-г тухайн сарын өдрийн тоо (бичилт хоорондын хугацаа)-гоор үржүүлсэн дүнд харьцуулж тодорхойлно. Үүнд:

$$P_{\text{х.и. сар}}^{\text{тарифт}} = \frac{\sum W_{\text{сар}}^{\text{оройн хэрэглээ}}}{5 * t_{\text{сарын өдөр}}}, \text{ кВт}$$

$P_{\text{х.и. сар}}^{\text{тарифт}}$  – Цагийн ялгаварт тарифт тоолууртай хэрэглэгчийн тухайн сарын оргил ачааллын үед (17.00-22.00 цаг) хэрэглэсэн хамгийн их чадлын дундаж утга (кВт);

$W_{\text{сар}}^{\text{оройн хэрэглээ}}$  – Хэрэглэгчийн оргил ачааллын үед (17.00-22.00 цаг) хэрэглэсэн сарын хэрэглээ (кВт.ц);

$t_{\text{сарын өдөр}}$  – Тухайн сарын хуанлийн өдрийн тоо буюу бичилт хоорондын хугацаа;

5.2.7. Баруун бүсийн эрчим хүчний нэгдсэн сүлжээнд холбогдсон, цагийн ялгаварт тарифын ангилал мөрддөггүй 24 цагийн үйл ажиллагаатай үйлдвэр, аж ахуйн нэгж, байгууллагад төлбөр тооцох чадлын хэмжээг тогтоохдоо тухайн сарын нийт цахилгаан энергийн хэмжээг 24 цагаар тухайн сарын хоног (бичилт хоорондын хугацаа)-оор үржүүлсэн дүнд харьцуулж тодорхойлно. Үүнд:

$$P_{\text{х.и. сар}}^{\text{энгийн}} = \frac{\sum W_{\text{сар}}}{24 * t_{\text{сарын өдөр}}}, \text{ кВт}$$

$P_{\text{х.и. сар}}^{\text{энгийн}}$  – Энгийн тоолууртай хэрэглэгчийн тухайн сард хэрэглэсэн хамгийн их чадлын дундаж утга (кВт);

$W_{\text{сар}}$  – Сарын цахилгааны хэрэглээ (кВт.ц);

$t_{\text{сар}}$  – Тухайн сарын чадлын хэмжээг тооцох хугацаа (цагаар);

$t_{\text{сарын өдөр}}$  – Тухайн сарын хуанлийн өдрийн тоо буюу бичилт хоорондын хугацаа;

5.2.8. Цахилгаан түгээх, хангах тусгай зөвшөөрөл эзэмшигч нь хэрэглэгчийн хэрэглэсэн цахилгааны чадлын хэмжээ болон чадлын төлбөрийг хэрэглэгчийн төлбөрийн нэхэмжлэх хуудсанд үзүүлнэ.

5.2.9. Хэрэглэгч цахилгаан тоолуурын заалтыг хянах боломжийг цахилгаан түгээх, хангах тусгай зөвшөөрөл эзэмшигч нь бүрдүүлнэ.

5.2.10. “Цахилгаан эрчим хүч хэрэглэх дүрэм”-ийн дагуу трансформаторын хоосон явалтын алдагдал тооцогддог хэрэглэгчийн хувьд хоосон явалтын алдагдалд ногдох энергийн хэмжээнд чадлын төлбөр тооцохгүй.

5.2.11. “Цахилгаан эрчим хүч хэрэглэх дүрэм”-ийн дагуу цахилгааны нөхөн тооцоо хийсэн нөхцөлд нөхөн тооцоо хийсэн цахилгаан эрчим хүчний энергийн хэрэглээ болон нөхөн тооцоолол хийсэн хугацааг үндэслэн чадлын төлбөр тооцно.

5.2.12. Техникийн шалтгаанаар чадал бүртгэх боломжтой тоолуурын санах ойд чадлын утгууд бүртгэгдээгүй тохиолдолд тухайн сарын оргил ачааллын үед хэрэглэсэн цахилгаан энергийн хэмжээг оргил ачааллын үргэлжлэх хугацаанд харьцуулж чадлын утгыг тодорхойлно.

5.2.13. Хэрэглэгчийн чадлын итгэлцүүр ( $\cos\phi$ )-ээс хамааруулж төлбөр тооцож буй цахилгааны хэрэглээнд чадлын төлбөр ногдуулахгүй.

5.2.14. Нийтийн зориулалттай байрны орцны гэрэлтүүлэг, цахилгаан шат, гарааж, подвалын хэрэглээнд чадлын төлбөр ногдуулахгүй. Сууц өмчлөгчдийн холбоо нь өөрийн эзэмшлийн шугам сүлжээнээс бусад аж ахуйн нэгж байгууллагыг холбосон нөхцөлд тэдгээр аж ахуйн нэгж байгууллагуудын цахилгаан хэрэглээнд чадлын төлбөрийг тооцно.

5.3. “Нийгмийн халамжийн дэмжлэг, туслалцаа зайлшгүй шаардлагатай хэрэглэгчдэд мөрдөх цахилгааны тариф”-т Нийгмийн халамжийн тухай хуулийн 3.1.2-т зааснаар амьжиргааны түвшин нь тухайн үеийн ядуурлын шугамаас доогуур үнэлэгдсэн дараах хэрэглэгчид хамрагдана. Үүнд:

5.3.1. Тэжээн тэтгэх төрөл садангүй, ганц бие ахмад настан;

5.3.2. Байнгын асаргаа шаардлагатай иргэн;

5.3.3. 0-18 хүртэлх насны гурав болон түүнээс дээш хүүхэдтэй өрх толгойлсон эх/эцэг;

5.3.4. Хөгжлийн бэрхшээлтэй иргэн

5.4. Нийгмийн халамжийн дэмжлэг, туслалцаа зайлшгүй шаардлагатай хэрэглэгчдэд цахилгааны тарифыг мөрдөхөд эрх бүхий байгууллагаас баталгаажуулсан хэмжих хэрэгсэлтэй, хангагчтай цахилгаан эрчим хүчээр хангах гэрээ байгуулсан, төлбөрийн үлдэгдэлгүй байх гэсэн нөхцөлүүдийг хангасан байна.

5.5. Нийгмийн халамжийн дэмжлэг туслалцаа зайлшгүй шаардлагатай хэрэглэгчдэд мөрдөх цахилгааны тарифт хамрагдахыг хүссэн 5.3.1-5.3.4-т заасан хэрэглэгч нь хүсэлтээ бичгээр гаргах бөгөөд дараах материалуудыг бүрдүүлнэ. Үүнд:

а) Тэжээн тэтгэх төрөл садангүй, ганц бие ахмад настан;

1. Баг, хорооны Засаг даргын тодорхойлолт /ам бүл, оршин суугаа газрын хаяг/
2. Төрөл садангийн (садангүйн) лавлагаа;
3. Өргөдөл;
4. Иргэний үнэмлэхийн хуулбар;
5. Нийгмийн халамжийн тухай хуулийн 3.1.2-т заасан ядуурлын шугамаас доогуур өрхийн гишүүнийг тодорхойлсон тодорхойлолт;
6. Үл хөдлөх хөрөнгийн гэрчилгээний хуулбар;
7. Газрын гэрчилгээний хуулбар;

б) Байнгын асаргаа шаардлагатай иргэн:

1. Баг, хорооны Засаг даргын тодорхойлолт /ам бүл, оршин суугаа газрын хаяг/
2. Байнгын асаргаа шаардлагатай тухай эрүүл мэндийн байгууллагын тодорхойлолт;
3. Өргөдөл (тухайн иргэн өргөдөл гаргах чадамжгүй бол асран хамгаалагчийн өргөдөл);
4. Иргэний үнэмлэхийн хуулбар;
5. Асран хамгаалагчийн иргэний үнэмлэхийн хуулбар;
6. Нийгмийн халамжийн тухай хуулийн 3.1.2-т заасан ядуурлын шугамаас доогуур өрхийн гишүүнийг тодорхойлсон тодорхойлолт;
7. Үл хөдлөх хөрөнгийн гэрчилгээний хуулбар;
8. Газрын гэрчилгээний хуулбар;

- в) 0-18 хүртэлх насны гурав болон түүнээс дээш хүүхэдтэй өрх толгойлсон эх/эцэг:
1. Баг, хорооны Засаг даргын тодорхойлолт /ам бүл, оршин суугаа газрын хаяг/
  2. Хүүхдүүдийн төрсний гэрчилгээний хуулбар;
  3. Өргөдөл;
  4. Иргэний үнэмлэхийн хуулбар;
  5. Өрх толгойлсон тухай нотлох баримт /нас барсны гэрчилгээ, Гэрлэсний бүртгэлгүй лавлагаа, Гэрлэлт дуусгавар болсны лавлагаа гэх мэт/;
  6. Нийгмийн халамжийн тухай хуулийн 3.1.2-т заасан ядуурлын шугамаас доогуур өрхийн гишүүнийг тодорхойлсон тодорхойлолт;
  7. Үл хөдлөх хөрөнгийн гэрчилгээний хуулбар;
  8. Газрын гэрчилгээний хуулбар;

е) Хөгжлийн бэрхшээлтэй иргэн:

1. Баг, хорооны Засаг даргын тодорхойлолт /ам бүл, оршин суугаа газрын хаяг/
2. Хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг тодорхойлсон үнэмлэхийн хуулбар эсвэл Эрүүл мэндийн байгууллагын тодорхойлолт
3. Өргөдөл (тухайн иргэн өргөдөл гаргах чадамжгүй бол асран хамгаалагчийн өргөдөл);
4. Иргэний үнэмлэхийн хуулбар;
5. Асран хамгаалагчийн иргэний үнэмлэхийн хуулбар;
6. Нийгмийн халамжийн тухай хуулийн 3.1.2-т заасан ядуурлын шугамаас доогуур өрхийн гишүүнийг тодорхойлсон тодорхойлолт;
7. Үл хөдлөх хөрөнгийн гэрчилгээний хуулбар;
8. Газрын гэрчилгээний хуулбар;

5.6. Нийгмийн халамжийн дэмжлэг туслалцаа зайлшгүй шаардлагатай хэрэглэгчдэд мөрдөх цахилгааны тарифт хамрагдах хүсэлтийг хүлээн авснаас хойш ажлын 5 хоногийн дотор хамрагдах эсэх шийдвэрийг тухайн цахилгаан түгээх, цахилгаанаар зохицуулалттай хангах тусгай зөвшөөрөл эзэмшигч компанийн гүйцэтгэх захирлын тушаалаар томилогдсон эрх бүхий албан тушаалтан гаргана.

5.7. Бүрдүүлсэн материалыг архивд хадгална.

5.8. Нийгмийн халамжийн дэмжлэг, туслалцаа зайлшгүй шаардлагатай хэрэглэгч хэрэглэсэн цахилгаан эрчим хүчний төлбөрийг 3 сар дараалан төлөөгүй тохиолдолд гэрээг цуцлах үндэслэл болно.

5.9. Цахилгаан эрчим хүчийг зүй бусаар хэрэглэсэн нь баримтаар нотлогдсон эсхүл хугацаа заасан баримт бичгийн хугацаа дууссан нөхцөлд гэрээг цуцлах үндэслэл болно.

### **Зургаа. Дүрмийн биелэлтэд тавих хяналт, хүлээлгэх хариуцлага**

6.1. Энэхүү дүрмийн биелэлтэд хангагч, хэрэглэгч талууд болон Эрчим хүчний зохицуулах хороо, эрчим хүчний хяналтын улсын байцаагч хяналт тавина.

6.2. Энэхүү дүрмийг зөрчсөн этгээдэд Эрчим хүчний тухай хууль, холбогдох бусад хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээлгэнэ.